



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Гурванбулаг сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/135/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.bulgan@audit.gov.mn Булган аймаг Булган сум 2023 он	Булган аймаг дахь ТАГ-н дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 89009802 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Утас: Цахим хаяг: Аудитор: Б.Золжаргал Утас: 90119931 Цахим хаяг: zoljargalb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	9-11
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж.....	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 99
танай _____ ны № _____ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Д БАТХУЯГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс 73.1 сая төгрөгөөр санхүүжүүлж 6.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 21.2 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1.7 сая төгрөг, аймгийн Соёл урлагийн газраас 0.8 сая төгрөгийн дэмжлэг, 9.7 сая төгрөгийн хөгжим, хэрэгсэл үнэ төлбөргүйгээр нийлүүлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

D:/bichighereg/2022A41bot

006020106

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,417,494.00	20,882,867.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	6,819,457.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	6,819,457.52
3121	Төгрөг	-	6,819,457.52
31211	Төрийн сангийн харилцах	-	6,819,457.52
33	АВЛАГА	-	25,816.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	25,816.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,417,494.00	14,037,594.00
351	Түүхий эд материал	10,316,047.00	10,316,047.00
35110	Тусгай зориулалттай материал	10,316,047.00	10,316,047.00
354	Хангамжийн материал	2,101,447.00	3,721,547.00
35410	Бичиг хэргийн материал	21,000.00	21,000.00
35420	Аж ахуйн материал	2,080,447.00	3,700,547.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	37,195,851.77	42,414,683.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,195,851.77	42,414,683.26
392	Биет хөрөнгө	29,745,351.74	33,555,683.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	309,912,897.98	309,912,897.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	(303,722,429.75)	(305,443,000.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,438,854.16	36,139,954.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,608,047.52)	(20,782,949.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,554,382.00	18,554,382.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,124,863.13)	(16,620,159.53)
39217	Ном	11,294,558.00	11,794,558.00
393	Биет бус хөрөнгө	7,450,500.03	8,859,000.06
39301	Програм хангамж	1,000,000.00	2,680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(187,499.97)	(458,999.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,638,000.00	6,638,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	49,613,345.77	63,297,550.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	49,613,345.77	63,297,550.78
51	Засгийн газрын хувь оролцоо	49,613,345.77	63,297,550.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	81,187,220.74	81,187,220.74
51101	Өмч: - төрийн	81,187,220.74	81,187,220.74
512	Хуримтлагдсан үр дүн	(83,946,089.07)	(70,261,884.06)
51210	Өмнөх үеийн үр дүн	(83,946,089.07)	(83,946,089.07)
51220	Тайлант үеийн үр дүн	-	13,684,205.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	52,372,214.10	52,372,214.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	49,613,345.77	63,297,550.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	107,362,322.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	11,415,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	11,415,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	11,415,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,714,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	9,701,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	95,946,722.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	73,877,822.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	73,877,822.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	22,068,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	21,268,900.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	93,678,116.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	93,678,116.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	92,854,264.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	55,446,017.85
210101	Үндсэн цалин	-	45,954,025.29
210102	Нэмэгдэл	-	7,739,964.06
210104	Урамшуулал	-	1,752,028.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	6,828,560.09
210201	Тэтгэврийн даатгал	-	4,643,235.22
210202	Тэтгэмжийн даатгал	-	546,263.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	437,010.32
210204	Ажилгүйдлийн даатгал	-	109,252.63
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,092,798.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	18,604,177.00
210301	Гэрэл, цахилгаан	-	604,177.00
210302	Түлш, халаалт	-	18,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,612,400.00
210401	Бичиг хэрэг	-	152,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	527,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	278,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	595,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	872,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	872,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,717,341.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,717,341.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,773,768.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	111,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	6,662,268.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	823,852.54
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	823,852.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	823,852.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	13,684,205.01
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	13,684,205.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	97,661,222.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,714,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,714,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,714,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,714,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	95,946,722.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	73,877,822.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	73,877,822.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	22,068,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	21,268,900.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	89,176,394.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	89,176,394.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	87,837,911.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	55,471,833.85
210101	Үндсэн цалин	-	45,979,841.29
210102	Нэмэгдэл	-	7,739,964.06
210104	Урамшуулал	-	1,752,028.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	6,828,560.09
210201	Тэтгэврийн даатгал	-	4,643,235.22
210202	Тэтгэмжийн даатгал	-	546,263.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	437,010.32
210204	Ажилгүйдлийн даатгал	-	109,252.63
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,092,798.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	18,604,177.00
210301	Гэрэл, цахилгаан	-	604,177.00
210302	Түлш, халаалт	-	18,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,731,500.00
210401	Бичиг хэрэг	-	152,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	527,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	278,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	714,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	872,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	872,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,608,341.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,608,341.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	721,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	721,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,338,482.08
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,338,482.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,338,482.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	8,484,827.98
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,180,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,180,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,180,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	2,180,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(2,180,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	6,304,827.98
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,819,457.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-		-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-		-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	81,187,220.74	52,372,214.10	(83,946,089.07)	-	49,613,345.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	13,684,205.01		13,684,205.01
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,187,220.74	52,372,214.10	(70,261,884.06)	-	63,297,550.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,960,500.00	79,232,273.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,960,500.00	77,872,273.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,760,500.00	77,872,273.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,568,200.00	50,859,494.00
210101	Үндсэн цалин	41,552,200.00	35,963,175.55
210102	Нэмэгдэл	11,016,000.00	14,896,318.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,096,700.00	6,611,866.57
210201	Тэтгэврийн даатгал	4,994,000.00	4,577,492.52
210202	Тэтгэмжийн даатгал	525,700.00	508,593.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	420,500.00	406,874.68
210204	Ажилгүйдлийн даатгал	105,100.00	101,718.75
210205	Эрүүл мэндийн даатгал	1,051,400.00	1,017,187.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,734,600.00	18,559,263.00
210301	Гэрэл, цахилгаан	734,600.00	559,263.00
210302	Түлш, халаалт	18,000,000.00	18,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,088,000.00	987,450.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	153,000.00	153,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	655,000.00	654,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,000.00	379,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	79,500.00
210604	Урсгал засвар	300,000.00	299,700.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	-
210702	Дотоод албан томилолт	58,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,835,000.00	475,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	835,000.00	475,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,360,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,360,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,360,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	81,460,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	81,460,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	81,460,500.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,819,457.52

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гурванбулаг сумын Соёлын төвийн зорилго нь аймгийн соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг хангаж, ардын болон орчин үеийн соёл урлагийн үйлчилгээг олон талт хэлбэрээр хүргэж, соёлын бүтээлч үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин бүрдүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Соёлын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад эрх зүйн акт, тогтоомжуудыг мөрдөж ажилладаг

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөж ажиллаагүй байна.

Дотоод аудитын ажилтангүй, дотоод хяналтын ажил төлөвлөж ажиллаагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан "Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажилладаг. Үйл ажиллагаанд нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гурванбулаг сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,684.2 мянган төгрөгөөр буюу 27.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	6,819.4	6,819.4
Авлага	0.0	25.8	25.8
Бараа материал	12,417.5	14,037.6	1,620.1
Үндсэн хөрөнгө	37,195.8	42,414.6	5,218.8
Нийт хөрөнгө	49,613.3	63,297.5	13,684.2
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	81,187.2	81,187.2	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	49,613.3	63,297.5	13,684.2

Дээрх хүснэгтээс харахад:

- ✓ Мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл төвлөрүүлэгдэхээ больсноос үүссэн байна.
- ✓ Ажилтны ХХОАТ-н өглөгийг дутуу тайлагнасан.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 1,620.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдаж авсан бараа материалаас зарцуулагдаагүй үлдэгдэл байна.
- ✓ Үндсэн хөрөнгө тайлант онд нийт 11,881.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба аймгийн Соёл урлагийн газраас 9,701.1 мянган төгрөгийн компьютер, техник хэрэгсэл үнэ төлбөргүй шилжүүлж, 180.0 мянган төгрөгөөр мэдээний программ, 1,500.0 мянган төгрөгөөр санхүүгийн программ, 500.0 мянган төгрөгөөр ном тус тус худалдан авч бүртгэлд тусгасан байна. 6,662.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг байгуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны үйл ажиллагааны зардлыг 95,565.3 мянган төгрөгөөр тооцож төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал 52,932.2 мянган төгрөгөөр тооцоолсноос 50,314.9 мянган төгрөгөөр батлагдаж 2,617.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 6,616.5 мянган төгрөгөөр тооцоолсноос 6,289.3 мянган төгрөгөөр батлагдаж 327.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2,865.2 мянган төгрөгөөр тооцоолсноос 1,088.0 мянган төгрөгөөр батлагдаж 1,777.2 мянган төгрөгөөр, эд, хогшил урсгал засварын зардлыг 5,678.0 мянган төгрөгөөр тооцоолсноос 1,100.0 мянган төгрөгөөр батлагдаж 4,578.0 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 518.0 мянган төгрөгөөр тооцоолсноос 58.0 мянган төгрөгөөр батлагдаж 460.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,936.3 мянган төгрөгөөр тооцоолсноос 0.0 төгрөгөөр батлагдаж 4,936.3 мянган төгрөгөөр, нэг удаагийн

тэтгэмж урамшууллыг зардлыг 780.0 мянган төгрөгөөр тооцоолсноос 768.0 мянган төгрөгөөр батлагдаж 12.0 мянган төгрөгөөр тус тус дутуу батлагдсан. Мөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 7,526.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.0 төгрөгөөр тооцоолсныг 5,680.0 мянган төгрөгөөр батлагдаж 5,680.0 төгрөгөөр илүү батлагдсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71702-Соёл урлаг-улсын төсөв	75,877.8	69,058.3	6,819.4	91.1%
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	69,290.1	65,443.7	3,825.8	94.9%
2	80214-Уран бүтээл хийлгэх	3,000.0	2,995.1	4.9	99.8%
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	768.0	0.0	768.0	0.0
4	81941-Соёлын байгууллагад гүйцэтгэлээр олгох санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0
5	83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	1,900.0	619.5	1,280.5	32.6%
	71702-Соёл урлаг-орон нутгийн төсөв	21,268.9	20,959.55	309.4	98.5%
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	18,913.4	18,604.2	309.2	98.4%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	2,355.5	2,355.3	0.2	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Тус Соёлын төв нь нэмэлт санхүүжилтийн дансаар ажил гүйлгээ бүртгэгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Тэмцээн уралдааны шагналыг Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар батлагдсан "төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын дагуу бүртгэл хөтлөх, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын дагуу зардлыг төлөвлөж зарцуулж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь ТАГ-ын аудитор Б.Золжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь ТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардал 90,017.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,350.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 1,080.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 удаагийн 55,281.9 мянган төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлэхээс 5 удаагийн 32,435.5 мянган төгрөгийн орлого, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 10 удаагийн 14,523.9 мянган төгрөгийн тушаал шийдвэр мэдээлэхээс 3 удаагийн 1,363.5 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд илэрсэн алдаа, зөрчилгүй.

Шийдвэрлэсэн нь:

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаашид зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” журмын дагуу бүртгэж тайлагнахад анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 470.6 мянган төгрөгийн төлбөрийн баримтгүй ажил гүйлгээний баримтыг нөхөж авч, ХХОАТ-н 25.8 мянган төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасныг аудитын явцад залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Шатахууны зарцуулалтыг шалгахад Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390-р тушаалын 1-р хавсралт "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг 411.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хэтрүүлэн зарцуулсан 411.5 мянган төгрөгийг аймгийн төсвийн орлого болгож, төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй, үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг зохих журмын дагуу хийж тооцоо бодоогүй.

Энэ нь ННБ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д "Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-д "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх", 72 дугаар зүйлийн 72.4-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих, комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай хийж үр дүнг бүртгэлд тусган биелэлт ирүүлэх албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн кассын бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тэмцээн уралдааны шагналыг нярвын хувийн дансанд шилжүүлж олгосон,

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1-р хавсралтын 4.9, Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар батлагдсан "төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын дагуу бүртгэл хөтлөх

2. Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудлаар

2.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу төсөвлөөгүйгээс 210801 зардлаас бараа материал, хөрөнгө бэлтгэсэн

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-н дагуу зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 08 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

